



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Л.Галбадрах
Утас: 99084291
цахим хаяг: L.Galbadrah@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--------------------------------------------------------------------------------------|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 12 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 12 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 13 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 13 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт | 14 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл | 14 |
| 3.5.3 Нэмэлт төсөв | 14 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 14 |
| 4.1 Ерөнхий зүйл | 14 |
| 4.2 Материаллаг байдал | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 15 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Л.БАТБАЯР ТАНАА

2023.02.24 № 02/89
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд 52 арга хэмжээ зохион байгуулж, тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын мод үржүүлгийн талбайд модны үржүүлгийн 75000 ширхэг харандаа бэлтгэж, хавар, намрын мод тарилтаар 292 аж ахуйн нэгж, байгууллагын 8819 иргэн, 175,136 мод, бут сөөг тариалж, 20 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, мэдээ, мэдээллээ олон нийтэд нээлттэй хүргэхийн тулд киоск машин нэвтрүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

021020339

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|-----------------------------------------------------------------------|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>8,527,269.00</u> | <u>10,988,048.00</u> |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8,527,269.00 | 10,988,048.00 |
| 354 | Хангамжийн материал | 8,527,269.00 | 10,988,048.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 162,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,045,269.00 | 10,668,048.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 320,000.00 | 320,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>655,799,141.16</u> | <u>648,445,206.51</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 655,799,141.16 | 648,445,206.51 |
| 392 | Биет хөрөнгө | 96,739,641.04 | 89,485,706.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,341,520.00 | 3,341,520.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,002,456.00 | -1,336,608.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,606,136.00 | 39,606,136.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -30,640,601.02 | -33,092,290.42 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 115,538,193.15 | 120,708,193.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -55,804,865.46 | -72,612,397.66 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,180,679.11 | 40,180,679.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -22,193,251.98 | -25,209,527.27 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,000,000.00 | 21,500,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,285,712.76 | -3,599,998.40 |
| 393 | Биет бус хөрөнгө | 559,059,500.12 | 558,959,500.00 |
| 39301 | Програм хангамж | 1,450,000.00 | 1,450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,349,999.88 | -1,450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 558,959,500.00 | 558,959,500.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>664,326,410.16</u> | <u>659,433,254.51</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>664,326,410.16</u> | <u>659,433,254.51</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 664,326,410.16 | 659,433,254.51 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 666,659,446.13 | 666,659,446.13 |
| 51101 | Өмч: - төрийн | 107,699,946.13 | 107,699,946.13 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 558,959,500.00 | 558,959,500.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -2,571,079.04 | -7,464,234.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -2,571,079.04 | -2,571,079.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -4,893,155.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 238,043.07 | 238,043.07 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>664,326,410.16</u> | <u>659,433,254.51</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 527,174,774.60 | 523,842,167.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,783,874.60 | 10,838,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,783,874.60 | 10,838,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,145,000.00 | 3,785,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,145,000.00 | 3,785,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 516,390,900.00 | 513,003,667.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 60,553,800.00 | 63,743,867.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 53,662,500.00 | 10,031,967.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,891,300.00 | 51,211,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,500,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 455,837,100.00 | 449,259,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 455,837,100.00 | 449,259,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 532,697,050.04 | 528,735,322.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 532,697,050.04 | 528,735,322.65 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 525,994,233.58 | 521,206,675.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 370,220,900.00 | 371,743,011.11 |
| 210101 | Үндсэн цалин | 290,010,150.00 | 287,832,024.11 |
| 210102 | Нэмэгдэл | 52,887,558.00 | 59,808,987.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,323,192.00 | 24,102,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,772,871.54 | 46,101,139.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,964,071.54 | 31,735,627.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,702,200.00 | 3,714,824.32 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,961,800.00 | 3,031,474.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 740,400.00 | 678,086.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,404,400.00 | 6,941,127.53 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,557,708.00 | 25,001,415.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 830,400.00 | 642,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,815,520.00 | 7,970,335.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,162,800.00 | 1,083,540.00 |

| | | | |
|--------|----------------------------------------------------------------------|----------------------|----------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 27,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,628,988.00 | 15,277,140.00 |
| 2105 | Нормативт зардал | 4,122,220.00 | 1,441,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,122,220.00 | 1,441,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,364,494.00 | 374,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,698,394.00 | 374,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,666,100.00 | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,262,500.00 | 7,068,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,262,500.00 | 7,068,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,575,502.00 | 45,794,375.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,615,400.00 | 41,162,417.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000.00 | 238,230.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 149,600.00 | 129,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44,900.00 | 37,628.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 27,500.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 110,000.00 | 100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,270,400.00 | 4,064,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 77,702.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,118,038.04 | 23,683,034.65 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,701,200.00 | 659,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,416,838.04 | 23,023,934.65 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,702,816.46 | 7,528,647.01 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,234,850.00 | 5,165,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,234,850.00 | 5,165,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 467,966.46 | 2,363,647.01 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 467,966.46 | 2,363,647.01 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -5,522,275.44 | -4,893,155.65 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -5,522,275.44 | -4,893,155.65 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|-----------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | | |
| | | 518,067,933.54 | 516,788,667.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,145,000.00 | 3,785,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,145,000.00 | 3,785,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,145,000.00 | 3,785,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,145,000.00 | 3,785,000.00 |

| | | | |
|---------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | |
| | | 515,922,933.54 | 513,003,667.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| | | -467,966.46 | 00.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| | | -467,966.46 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| | | 60,553,800.00 | 63,743,867.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| | | 53,662,500.00 | 10,031,967.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| | | 6,891,300.00 | 51,211,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| | | 00.00 | 2,500,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | |
| | | 455,837,100.00 | 449,259,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| | | 455,837,100.00 | 449,259,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | | |
| | | 518,067,933.54 | 516,788,667.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | |
| | | 518,067,933.54 | 516,788,667.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | |
| | | 511,833,083.54 | 509,260,019.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | |
| | | 370,220,900.00 | 371,743,011.11 |
| 210101 | Үндсэн цалин | | |
| | | 290,010,150.00 | 295,565,511.11 |
| 210102 | Нэмэгдэл | | |
| | | 52,887,558.00 | 61,802,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| | | 27,323,192.00 | 14,374,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | |
| | | 49,772,871.54 | 46,101,139.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | |
| | | 34,964,071.54 | 31,600,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | |
| | | 3,702,200.00 | 2,974,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | |
| | | 2,961,800.00 | 3,717,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | |
| | | 740,400.00 | 732,484.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | |
| | | 7,404,400.00 | 7,076,754.95 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| | | 15,838,140.00 | 19,238,694.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| | | 892,400.00 | 333,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| | | 6,815,520.00 | 7,970,335.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | |
| | | 1,162,800.00 | 1,083,540.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| | | 120,000.00 | 175,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| | | 6,847,420.00 | 9,676,419.00 |
| 2105 | Нормативт зардал | | |
| | | 3,299,970.00 | 1,441,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| | | 3,299,970.00 | 1,441,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | |
| | | 35,162,000.00 | 5,544,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| | | 33,495,900.00 | 5,544,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| | | 10,262,500.00 | 7,068,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | |
| | | 10,262,500.00 | 7,068,700.00 |

| | | | |
|--------|----------------------------------------------------------------------------|---------------------|---------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,575,502.00 | 57,464,375.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,615,400.00 | 52,832,417.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000.00 | 238,230.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 149,600.00 | 129,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44,900.00 | 37,628.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 27,500.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 110,000.00 | 100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,270,400.00 | 4,064,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 77,702.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,701,200.00 | 659,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,701,200.00 | 659,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,234,850.00 | 7,528,647.01 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,234,850.00 | 5,165,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,234,850.00 | 5,165,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 2,363,647.01 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,363,647.01 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--------------------------------------------------|------------------------------------------|-----------------------------|----------------------|-------------------------------------------------|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 666,659,446.13 | 238,043.07 | -43,789,520.92 | 623,107,968.28 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 382,688.11 | 382,688.11 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 666,659,446.13 | 238,043.07 | -43,406,832.81 | 623,490,656.39 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 45,358,029.21 | 45,358,029.21 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 666,659,446.13 | 238,043.07 | -2,571,079.04 | 664,326,410.16 |

| | | | | | |
|-----|---------------------------------------|----------------|------------|---------------|----------------|
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 666,659,446.13 | 238,043.07 | -2,571,079.04 | 664,326,410.16 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 666,659,446.13 | 238,043.07 | -2,571,079.04 | 664,326,410.16 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -4,893,155.65 | -4,893,155.65 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 666,659,446.13 | 238,043.07 | -7,464,234.69 | 659,433,254.51 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|-----------------------------------------------------------|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 449,259,800.00 | 446,931,152.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 449,259,800.00 | 446,931,152.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 443,652,900.00 | 441,766,152.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 371,765,200.00 | 371,743,011.11 |
| 210101 | Үндсэн цалин | 295,587,700.00 | 295,565,511.11 |
| 210102 | Нэмэгдэл | 61,802,700.00 | 61,802,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,374,800.00 | 14,374,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,470,700.00 | 46,101,139.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,600,000.00 | 31,600,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,974,200.00 | 2,974,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,717,700.00 | 3,717,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 743,500.00 | 732,484.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,435,300.00 | 7,076,754.95 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,357,300.00 | 9,165,944.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 333,400.00 | 333,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,889,400.00 | 5,886,735.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,272,000.00 | 1,083,540.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 175,000.00 | 175,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,687,500.00 | 1,687,269.00 |
| 2105 | Нормативт зардал | 3,300,000.00 | 1,441,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,300,000.00 | 1,441,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,637,500.00 | 5,544,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,070,800.00 | 5,544,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,566,700.00 | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,160,600.00 | 2,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,160,600.00 | 2,160,000.00 |

| | | | |
|---------|----------------------------------------------------------------------|----------------|----------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,302,500.00 | 4,951,958.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 336,800.00 | 320,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000.00 | 238,230.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 149,600.00 | 129,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44,900.00 | 37,628.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 27,500.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 110,000.00 | 100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,270,400.00 | 4,064,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 83,300.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 659,100.00 | 659,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 659,100.00 | 659,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 560,690.00 | 516,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,606,900.00 | 5,165,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,606,900.00 | 5,165,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 449,259,800.00 | 446,931,152.99 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 449,259,800.00 | 446,931,152.99 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 449,259,800.00 | 446,931,152.99 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 00.00 | 35,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 35,000.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 39.00 | 38.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 32.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|----------------------------------------------------------|---------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 63,743,867.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 63,743,867.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 63,743,867.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,072,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,083,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,989,150.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,908,700.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 4,908,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 52,512,417.00 |

| | | |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 52,512,417.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 63743867.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 63,743,867.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,031,967.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 51,211,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар “Төр засгийн бодлогын хүрээнд аймгийн байгаль орчин, түүний баялгийн суурь судалгаанд тулгуурласан мэдээллийн сан бүрдүүлж, хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх” зорилгын хүрээнд 7 зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар Монгол улсын Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “Байгаль орчин, аялал жуулчлалын газар” нэртэй болж, дарга-1, мэргэжилтэн-7, үйлчилгээний ажилтан-6, сумдын байгаль хамгаалагч-24, нийт 38 орон тоотой ажиллаж байгаа.

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын тайлант хугацаанд өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын мод үржүүлгийн талбайд модны үржүүлгийн 75000 ширхэг харагдаа бэлтгэж, хавар, намрын мод тарилтаар 292 аж ахуйн нэгж, байгууллагын 8819 иргэн, 175,136 мод, бут сөөг тариалж, 20 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, мэдээ, мэдээллээ олон нийтэд нээлттэй хүргэхийн тулд киоск машин нэвтрүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 сарын 16 өдрийн А/34 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд аймгийн Төрийн аудитын газраас нийцлийн аудит, дотоод хяналтын аудитаас 2020-2022 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.8 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөгөөр/ | | | |
|------------------------------------------|----------------|-----------------|-----------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 8,527.2 | 10,988.0 | 2,460.8 |
| Үндсэн хөрөнгө | 655,799.1 | 648,445.2 | (7,353.9) |
| Нийт хөрөнгө | 664,326.3 | 659,433.2 | (4,893.1) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 664,326.4 | 659,433.2 | (4,893.2) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 664,326.4 | 659,433.2 | (4,893.2) |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Тайлант онд өр,авлага үүсээгүй.
- ✓ Бараа материал өсөхөд тайлант онд 20.3 сая төгрөгний материал худалдан авч, үнэ төлбөргүй 9.0 сая төгрөгийн бараа материал хүлээн авсан байна.

- ✓ Үндсэн хөрөнгө нэмэгдсэн 2 ширхэг компьютер худалдан авч, элэгдлийн зардлаар буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 693.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 243.9 сая төгрөгөөр буурч 449.2 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь улсын төсвөөс 449.2 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 446,9 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 2.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт дансанд 63.7 сая төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр 63.7 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Л.Галбадрах 2022 оны 02 дугаар сарын 16-наас 02 дугаар сарын сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 21 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны 4-р улирлын тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон. Нийт зардлын 523.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр тогтоож баримтжуулсан.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээлэл хугацаандаа оруулах ёстойгоос 150 мэдээллийн бүрэн байршуулж, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/ алдаа зөрчил илэрсэнгүй.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Л.ГАЛБАДРАХ

